

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть ХХХХ (463)

2016

(208-213)

**ХИЧЭЭНГҮЙ АМАРЛИНГУЙ УЛСЫН ГҮНЖИЙН
ГЭРЭЛТ ХӨШӨӨНИЙ МАНЖ БИЧЭЭС**

М. Баярсайхан *

Түлхүүр үг: Хичээнгүй амарлингуй улсын гүнж, тахилгын сүмийн гэрэлт хөшөө, хөшөөний манж бичээс

Бидний энэ хир олж мэдсэнээр Монгол улсын нутагт эдүгээ уламжлан ирсэн хөшөө чулуу болон хадны манж бичээс 7 байна¹. Үүний нэг нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг, Баян уулын өвөр, Хөх чулууны голын эхэд буюу хойд өргөргийн 48°73', зүүн уртрагийн 107°47' солбицолд Улаанбаатар хотоос зүүнш 120 орчим км зайд орших² Гүнжийн сүмийн гэрэлт хөшөөний манж, хятад бичээс юм. Тус өгүүлэлд уг гэрэлт хөшөөний манж бичээсийг уншиж галиглан манж бичгийн сийрүүлэг, үг хэллэгийн тайлбарын хамт толилуулж байна. Үүнийг мөн З.Оюунбилэг, Ж.Наранчимэг нарын хэвлүүлсэн Гүнжийн сүм номд оруулсан бөгөөд энэ удаад бага зэрэг засвар оруулахын хамт Хичээнгүй амарлингуй гүнжид холбогдох манай судлаачдад шинэ сэргэг байгуужин гэж үзсэн манж сурвалжийн нэгэн мэдээг нийтлүүлэхийг зорив. Гэрэлт хөшөөний хэмжээ хэлбэр, яст мэлхийн суурь болон хөшөөний магнайн хэсгийн ур хийц, бусад дэлгэрэнгүй мэдээллийг дурдсан номд тун тодорхой судлан бичсэн тул энд үл давтана.


Миний бие тус хөшөөний манж бичээсийг уншихдаа З.Оюунбилэг, Ж.Наранчимэг нарын 2014 онд авсан маш сайн хуулга дардсын гэрэл зургийг ашигласан бөгөөд нэрт манжич, түүхч эрдэмтэн Л.Дэндэвийн хөшөөний бичээсийн сийрүүлгийг хяналт болгож харьцуулав. Дардасны хувьд цаад бичээсний элэнхийг даган цөөн хэсэг бүдэг балархай тохиолдовч, хам сэдэв, үг үсгийн зай хэмжээнээс багцаалан зөв сэргээж унших бүрэн боломжтой байв. Л.Дэндэв гуай тус хөшөөний манж бичээсийг сийрүүлэн хуулж авсан

* МУИС, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

¹ Энэхүү 7 бичиг нь: Амарбаясгалант хийд дэх гэрэлт хөшөөний манж, монгол, хятад бичээс (1737), Дамбадаржаалин хийдийн манж монгол, хятад төвд бичээс бүхий хоёр гэрэлт хөшөө (1765), Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг дахь Бичигт чулууны манж бичээс (1700), Архангайн Тайхар чулууны манж бичээс (1722), Увсын Өлгий сумын нутаг дахь манж бичээс, Завхан аймгийн нутаг дахь Жинст хайрхан уулын манж бичээс зэрэг болно. Эдгээрээс гадна Түгээмэл амаржуулагч сүм /Шар сүм/ (Ховд аймаг, Буянт голын орчим 1767)-ийн манж, монгол, хятад 3 хэлээр бичсэн хөшөө чулуу байсан боловч, түүх соёлын дурсгалыг үл хайрлагчдын балгаар нэгэнтээ сүйджээ.

² Гүнжийн сүмийн байрлалын тухай мэдээг Зундуйн Оюунбилэг, Жуковын Наранчимэг нарын Гүнжийн сүм (УБ, 2016) номын 77-р талаас авав.

байсныг маршал Х.Чойбалсангийн хувийн нарийн бичгийн дарга Г.Бат-Очир дам тэмдэглэж авсан нь УТНОНБА(Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын архив)-т хадгалагдаж байна³. Тэрхүү тэмдэглэлийг үзэхэд Г. Бат-Очир нь цэг дусал, ацаг алдах, ацаг нэмэх, ойролцоо дүрс бүхий үсгийг зөрүүлэх зэргээр алдаж сийрүүлсэн зүйл цөөнгүй, гэвч энэ нь Л.Дэндэв гуайн уг тэмдэглэл ямар байсныг мэдэхэд бэрхшээл болохооргүй байна. Миний бие дардас ашиглан уншсаныгаа Л.Дэндэв гуайн уншсантай харьцуулахад бараг тохирч байгаа бөгөөд бичээсийн 3 дугаар мөрт “sain-be tuwakiyame”, 5 дугаар мөрт “dahime isibuha” гэж бичсэнийг Л.Дэндэв гуайн сийрүүлэгт “beye-be tuwakiyame”, “dahime isibume” гэж бичсэн хоёр зөрүү байна. Хөшөөний бичээс ерийн үзэхэд тун балархай мэт авч, тусгай дардасны цааснаа хэв хуулга авахад бүрэн уншигдахаар байгааг анхаарна биз ээ. Чухам ийм учраас, Ц.Дамдинсүрэн гуай хөшөөний бичээс тун балархай, цөөн хэдхэн манж үг үлдсэн хэмээн тэмдэглэсэн байдаг.



Гүнжийн сүмийн гэрэлт хөшөөний манж бичээсийн галиг:

1. dorolon dorgi durun-de ureme ofi aifini-ci fulgiyan fi-i sain-be ejehe. jurgan hanci niyaman-be jiramilame ofi ambaramе
2. hesei* bidhei elden-be iletulehe. togtoho kooli-be yongkiyame yabubume ulaha yabun-be enteheme temgetulembi. ginggun elhei gurun-i gungju si gargan abkai fisen-ci fusehe, wesihun gu-i abdaha-ci dendehe.

³ УТНОНБА, Хөмрөг -17, Д-1, Хн-57

3. nesuken nemgiyen-i banin salgabufi wecere baita-de gingguleme sain-be tutabuha gingguji olhoba-i sain-be tuwakiyame ashaha gu-de acanafi magtacun algiqa. bederehe aniya sangqangge goidaha-be gūnici erin forgon
4. emdubei gurinjihe kooli dorolon-i wesihuleci acara-be kimcifi
5. kesi fulehun-be dahime isibuha wecere jaka-be benebuhe bime, geli bei wehe ilibumbi. ai. eifu musen-de tugi borhome gulu mengse(?) -i elden enteheme burubuha.
6. hesei bidhe-de šun jergišeme šeri fejergi-de isitala elden ambula nonggibuha (s)ini juse omosi gingguleme ali:
7. abkai wehiyehe-i sunjaci aniya jorgon biyai orin juwe:

Орчуулга:

1. Ёслол, дотоод дүрэмд боловсорсон тул хэдийнээс улаан бийрээр сайныг тэмдэглэвэй⁴. Журам ойр, ургийг хүндэтгэсэн тул
2. Зарлигийн бичгээр гэрлийг ихэд илэрхийлбэй⁵. Тогтсон хуулийг төгсгөн⁶ явуулж уламжилсан явдлыг үүрд тэмдэглэмүй. Хичээнгүй амарлингуй улсын гүнж чи тэнгэрийн удмаас⁷ өссөн, эрхэм хасын навчнаас гарсан салаа буюу.
3. Дөлгөөн онгон⁸ төрөлх хувь зохиож, тайх хэрэгт хичээнгүйлэн сайныг хоцоргов. Хичээнгүй болгоомжтойгоор сайныг сахиж, зүүсэн хас⁹ лугаа зохилдоод магтаал алдаршив. Эгсэн жил сунжирсан нь удсаныг санаваас цаг улирал
4. байн байн шилжив. Хуульд ёслолоор эрхэмлэвээс зохихыг хянаж
5. хишиг өглөгийг дахин хүртээв. Тайх юмыг хүргүүлсэн агаад бас хөшөө чулуу байгуулмуй.
Аяа, шарил булшнаа үүл цогцолж, шулуун хөшгийн?¹⁰ гэрэл үүрд бүрхэгдвэй.
6. Зарлигийн бичигт наран зэрэгцэж булгийн доод хүртэл ихэд гэрэл нэмэгдэв. Чиний хөвгүүд ач нар хичээнгүйлэн хүлээ¹¹.
7. Тэнгэрийн тэтгэсний тавдугаар он арван хоёр сарын хорин хоёр.

* Мөр тэтгэж бичсэн үгсийн галигийг доогуур нь зураастай тэмдэглэв.

⁴ Улаан бийрээр тэмдэглэх – Хаан аливаа айлтгалыг үзэж танилцаад, хариу зарлиг буулгахдаа улаан бийрээр цохож тэмдэглэдэг. Энд мөнхүү гүнжийн талаар цохон тэмдэглэж байсныг өгүүлжээ.

⁵ Гэрлийг ихэд илэрхийлэх - Үлэмж гавьяатай бичиг, цэргийн сайд түшмэд, хааны угсаа төрлийн хүнийг нас барсны хойно хааны зарлигаар алдаршуулан босгосон хөшөөг гэрэлт хөшөө гэнэ. Гэрлийг ихэд илэрхийлбэй гэж хөшөөнд алдрыг нь тэмдэглэснийг хэлж байна.

⁶ Төгсгөн- Бүрэн гүйцэтгэн гэсэн утгаар ойлгоорой.

⁷ Тэнгэрийн удам- Хааны удам

⁸ Онгон- Хуучин бичгийн хэлнээ элэгсэг, найртай гэсэн утгаар хэрэглэдэг байсан үг.

⁹ Зүүсэн хас- Хааны тамгыг хасаар үйлдэнэ. Хааны угсаагийн тэмдэглэлийг хас дэвтэр гэж байсан бөгөөд бас хас чулуунд сийлж бичдэг байжээ. Түүнчлэн навчит өргөмжлөл, навчит бичгийг бас хасын навчит бичиг гэдэг байсныг академич И.В.Захаров “Манж орос бүрэн толь”-доо /355т/ тэмдэглэжээ. Хаан олгодог тул тийнхүү хасын гэж өргөн нэрлэх явдал байсан биз ээ. Энд зүүсэн хас лугаа зохилдож гэсэн нь Хичээнгүй амарлингуй гүнжид олгосон алтан навчит өргөмжлөлийг хэлсэн байж болох юм.

¹⁰ Уг үг нь гаргахад бэрх балархай. Үлдсэн ор мөр нь ‘mengse’ гэж уншихаас илүү хувилбар байж болохыг нягталж олсонгүй. Манж хэлний мэнсэ-г монголоор хөшиг гэж орчуулна. Гэрийн хөшиг, орны хөшгөөс гадна “тайхад тавиурт өлгөдөг вааданг хөшиг хэмээмүй” (Хорин нэгтийн тайлбар толь, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1979, 425т) гэжээ. Гэвч хөшөөний бичээсэн дэх хөшиг бол орны хөшгийг хэлсэн хэрэг бөгөөд хөшгийн гэрэл үүрд бүрхэгдвэй гэсэн нь гүнж үүрд халин одвой гэсэн утга байж болохоор санагдана.

¹¹ Тосч ав, дааж хүлээ гэсэн утга.

Febqe-I ~w-;iyw-/E] I Suejec-I Feniya J-orgoa b8ye-I Foria Ju`W.

/E-sw-I b8oe/E] Xa Zua Jw-r;8zwm-W Zwri !wjwr;8A Xa Fi-si-tela Flxea FemVla N-o6;8Vha . Sin-I JusW Fomosi ;86:lw-m-W FeII.

F----e-5e-/E-mWVruBha.

kE-si ~ulw--?a vE] De/8mW Fisi-Vha ~wcwrW Jega ve] bwnw--V/E] b8mW ;EII vEI ~w-/E] FiliVmbI.
Fe-I, Fili`U Muswa Xa %o;8A BrhomW :lU Mw6sW I Flxea

Fmxove-I :rieji/E] QoolI Doroloa I ~w-si-?lwci Fecera vE] k8mci`I

Me0-tecua Fel;8qa . vE-xer-w--/E] Feniya Se6qe6;E] Goli-deha vE] Goinici Fria
~orgoa

Nw-sukea Nw--m;8ywa I bEnia Selge-V~I ~wcwrW bEli-ta Xa ;86:lw---m-W Seia vE] %oteVha.
;86:ji FolhobeI I Seia vE] %o`e-k8yemW Fesheha : Xa Fecene`I

G-erg-ea Febqe-I ~iswa c-I ~u-sw--k4, ~w-si--?a : -I Febdeha CI Xe-e-x-/e] .
/Esw-I b8-oe-/EI F-l-xea vE] Filw-5ol-w-/e] . To0-toh-O QoolI vE] Yo6k8y-emw Y-e-Vvmw Fuleha Y-
eva vE] F-----e5e-/E-mW %-em;E-5olw-mbI. ;86:a Fl/E-I :rua -I :6ju SI

Doroloa Dor;8A Xorua Xa Furw--m-W Fo`I Feil`i-n-I c-I ~ul;8-y-ee ~I I Seia vE] F-j-w-/E] .
Jurgea H-eeCI Niyem-ea vE] Jir-emilemW Fo`I Fe-mbEremW

Хөшөөний бичээсийн галиг, орчуулга, сийрүүлгийг толилуулахын ялдамд Түшээт хан, Дондовдорж ба Хичээнгүй амарлингуй улсын гүнжийн талаар гарсан ном зохиол, судалгааны бүтээлүүдэд хараахан дурдагдаагүй орхигдсон нэгэн түүхэн мэдээ, баримтыг дурдсуу.

Дайчин улсын магад хуульд: <<Тэнгэрийн тэтгэсний тэргүүн он, зуны дунд сарын хөхөгчин могой өдөр, Бүгд хэрэг шийтгэх ван сайдууд Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны сайдууд лугаа хамт нийлж хэлэлцсэн нь, эрхэлсэн сайд Тунжи нарын айлтгасан нь, Шүргэй хаалга(杀虎口)-ны гадна, Чиншүйхэ (清水河) хэмээх газрын тариаг урьд Халхын хичээнгүй амгалан улсын гүнж айлтгаад, тарьсан бүлгээ. Энх-Амгалангийн тавин гуравдугаар он Хаалганд явах хүн самуун будлиан хэмээн тариа тарихыг байгаад, урьд авсан тэмдэг бичгийг айлтгаж, явдлын яаманд тушаан өгсөн, гэвч гүнжийн доорхи ард басхүү хоёр завсраа тарьж, явбай. Эдүгээ эфү Дондовдорж Халхын газарт одмуй. Энэ газарт тариа тарих ардыг нэхэн захирч үл болмуй. Зүй нь энэ тариаг татан авч, иргэн элсэж тариулан, дарангуй цэргийн ардын амуунд хүрэлцүүлбээс зохимуй. Гагцхүү эфүгийн хүн энэ тариаг өдий чинээ жил тариад, тариаг боловсрол болгосны тулд, түмэдийн монголчуудын тариа худалдах үнийн ёсоор му бүр хошоод цэн мөнгө бодож, эфүгийн тэмдэглэсэн дансанд түүний хүний тарьсан Чиншүйхэ-гийн тариа дөрвөн түм найман мянга гурван зуун далан таван му-д есөн мянга зургаан зуун далан таван лан мөнгө шагнаваас зохих ба үл зохих явдлыг хишиг нь эзнээс гармуй хэмээжээ. Байцааваас урьд түшмэл бид Хөх хотын газарт тариа тариулах дарангуй цэргийн амууг хүрэлцүүлэхийн учир хэлэлцээд, эфү Дондовдорж Чиншүйхэгийн газарт тарьсан тариа, уг шагнасан тооноос хувийн нэмж хэтрээд хэд хэдэн түмэн жин болжээ. Эфү Дондовдорж Халхын газарт одсоны хойно, энэ зүйлийн тариаг эсвээс бас ч иргэн элсэж тариулахын тулд, Түнжи-д тушаан өгч, язгуур шагнасан тариаг байцааж, хэрхэн үнэ таацуулж, эфүд мөнгө шагнан өгөх ба түүний доорхи ардын илүү эзэлсэн тариаг татан гаргаж, хэрхэн шийтгэж тариулах явдлыг хэлэлцэж, айлтгуулсугай хэмээн айлтгаж явуулсныг дансанд тэмдэглэжээ. Эдүгээ эрхэлсэн сайд Түнжи нар тодорхойлон байцааж, Чиншүйхэгийн тариаг урьд Дондовдорж тарихыг байв хэмээн айлтгаж, тэмдэг бичгийг явдлын яаманд тушаан өгсөн бөгөөд хоёр хооронд өдий чинээ жил тарив. Зүй нь цөм татаж авбаас зохих бүлгээ. Гагцхүү эфүгийн хүн энэ тариаг тарьж боловсрол болсны тулд, түүний дансанд тэмдэглэсэн дөрвөн түм найман мянга гурван зуун далан таван му тарианд монголчуудын тариа худалдах үнийн ёсоор му бүр хошоогоод цэн мөнгө шагнах ажаамуу хэмээсний тулд, Түнжигийн айлтгасны ёсоор эфү Дондовдоржид есөн мянга зургаан зуун далан таван лан мөнгө шагнасугай. Чиншүйхэгийн газарт аху тарианы тоо жил бүр олох амууны тоог Түнжи нар гүйцэтгэн байцаагаад язгуурын айлтгасны ёсоор шийтгэтүгэй. Эфү Дондовдоржид шагнах мөнгийг түүний хүн гаргаж, тамга дарсан бичиг авч, нийслэл хотонд илгээж Сангийн явдлын яаманд автугай. Түнжи нарын бас айлтгасан нь Чиншүйхэгийн дорнод умараа Шарга морьтын нэгэн тариагаар газар, өрнөд умраа Олон (乌兰) байшингийн нэгэн тариагаар газар урьд монголчууд нутаглаж явсан бүлгээ. Хойно эфү монголчуудыг бусад газарт зөөн нүүлгэж жил удвай. Түшмэл бид тариа тарьж одсоор энэ зэрэг газарт хүрсний хойно, хуучин нутгийг хоморгоор ирэх монголчууд буй бөгөөс, магадлан байцаагаад тариа сайн болбоос му бүр хошоогоод цэн мөнгө шагнаж, өөр газарт шийтгэж суулгасугай. Хэрвээ тариан төгс үл болох болбоос даруй гэдрэг өгч нутаг болгосугай хэмээжээ. Байцааваас, энэ зэргийн газарт язгуураас монголчууд нутаглаж явсан бүлгээ. Огт тариа тарьж гэр байгуулснаас адилтгаваас үл болмуй. Эфү

Дондовдоржийн хүнд эзлэгдсэнээс бусад газарт зөөн нүүж, өдий чинээ жил сууж тогтжээ. Хэрвээ албаны тариа хагалан тарих цагт монголчууд хоморгоор ирэхийг нь үзэж даруй үнэтэй мөнгө олгуулбаас дэмий завшаан эрж заалдалцах хүн олон болоод байцаан шийтгэхэд будлиан болохыг болзошгүй. Үүнийг Түнжи нарт тушаан өгч Шарга морьт, Олон байшингийн зэргийн газарт язгуураас нутаглаж суусан монголчуудыг хянан магадлан байцааж, хэрвээ тэдний язгуурын тарьсан тариа болбоос эсвээс тариаг бодож үнэ олгуулах ба эсвээс төгс болохгүй мөнхүү нутаглаж явах газар болгох явдлыг ялган салгаж шийтгүүлсүгэй хэмээн айлтгасанд явуулбай»¹² хэмээн тэмдэглэжээ.

Тус мэдээний агуулгыг хураангуйлбал: Анх Хичээнгүй амарлингуй улсын гүнж хаанд айлтган Хөх хотоос урагш агч Чиншуйхэ орчим өөрийн хүмүүсээр тариа тариулж эхэлсэн бөгөөд тэнд язгуураас сууж байсан монголчууд өөр нутагт нүүсэн, 1714 онд Хаалган орчимд самуун дэгдсэн учир тариа тарихыг байсан, гэвч гүнжийн харьяат ард тариа тарьсаар ирсэн ба гүнжийг нас барсны хойно эфү Дондовдорж Халхад суугаар одсон тул тэдгээр тариа таригч ардыг захирч болохгүй болсон, манжийн дарангуй цэргийн хүнсний амууг хүрэлцүүлэхийн тулд тэр тарианы газрыг улсад татан авч, Дондовдорж ба тариа таригч ардад үнэ мөнгө шагнаан олгох, өөр газарт нутаг өгч шилжүүлэн суулгах талаар хэдэнтээ айлтган шийтгүүлж байсан тухай өгүүлжээ.

НОМЗҮЙ

1. Dayi'cing ulus-un magad qauli, qoyaduyar debter, Öbür Mongyol-un Suryan kümüjil-ün keblel-ün qoriy-a, Kökeqota, 2012
2. Ц.Дамдинсүрэн, Гүнжийн сүм, S.A. Т.Ц, F.3, Уб., 1961
3. И.Захаров, Полный маньчжурско-русский словарь, СПб., 1875
4. З. Оюунбилэг, Ж. Наранчимэг, Гүнжийн сүм, Уб, 2016, 176т
5. УТНОНБА(Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын архив), Хөмрөг -17, Д-1, Хн-57
6. Б.Түвшинтөгс, “Хичээнгүй Амгалан гүнжид олгосон алтан навчит өргөмжлөлийн тухайд” //Altaica II, Уб., 2002
7. Han-i araha dayi'cing gurun-i uheri qooli bidhe
8. Han-i araha manju gisun-i buleku bidhe

ABSTRACT

In this paper, the author introducing his transliteration of Manchu script with their translation, reproduction and explanation of words on stela where shrine of sacrifices of Ginggun Elhei Gurun-i gungju(Princess born to an Empress); queen of Dondubdorji who zasay(governor), doroi giyün wang(Prince of the Blood of the second degree) of Khalkha; and the princess of emporer Kangxi of Qing dynasty which are located in the front base of Bayan Mountain where Erdene soum, To'v province, Mongolia.

¹² “Дайчин улсын Монголын магад хууль”-ийн хоёрдугаар эмхэтгэл, 207-208-р тал.